

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс анхан шатлалын тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн нэн шаардлагатай зарим тусламж, үйлчилгээг иргэнд тэгш, хүртээмжтэй, тасралтгүй, чанартай, цогц байдлаар үзүүлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3. Энэхүү журмыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнууд мөрдөн ажиллана.
- 1.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг цаашид “Төв” гэнэ.

ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1. Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн, тэдний эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- 2.2. Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрд харьяалал харгалзахгүйгээр үйлчлэх;
- 2.3. Иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгт орчныг хангасан, иргэний сонголтыг хүндэтгэсэн “Хүн төвтэй цогц тусламж, үйлчилгээ”-г үзүүлэх;
- 2.4. Шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоонд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- 2.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох;
- 2.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулан, хэнийг ч орхигдуулахгүй байх,
- 2.7. Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чанартай, аюулгүй, чирэгдэлгүй, тасралтгүй, цогцоор үзүүлэх;

ГУРАВ. ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

- 3.1. Төв нь стандартын шаардлага, тусгай зөвшөөрөлд үндэслэн энэхүү тушаалын хавсралтад заасан тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний холбогдох журам, тушаал, эмнэл зүйн заавар, стандартыг мөрдөн иргэнд үзүүлнэ.
- 3.2. Төв нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг ажиллах нөхцөлийг ханган ажиллана.

3.3. Төв нь цахим бүртгэл, төрийн нэгдсэн цахим сүлжээнд холбогдох, зайн оношилгоо, мобайл болон дижитал технологийг ашиглан тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрэн хангасан байна.

3.4. Төв нь эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, харилцаа, хандлагын доголдол гаргахаас сэргийлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

3.5. Төв нь нутаг дэвсгэрийн нийт хүн амын бүртгэл судалгааг жил бүр шинэчлэн, иргэнийг эрүүл мэндийн бүлгээр ангилан, эрсдэлийг үнэлж, хяналт тогтоон, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.6. Эрүүл мэндийн байдлаар нь хүн амыг ангилах тухай:

3.6.1. **Эрүүл мэндийн 1-р бүлэг (цоо эрүүл):** Эмнэл зүйн үзлэг шинжилгээгээр биеийн болон сэтгэцийн ямар нэг өөрчлөлтгүй хүнийг хэлнэ.

3.6.2. **Эрүүл мэндийн 2-р бүлэг (эрүүл):** Энэ бүлэгт эмчилгээ шаардлагагүй, төрөлхийн ямар нэгэн согог, урьд нь өвчилсний үлдэцтэй, эсвэл өвчний эхлэл нууц үеийн зарим илрэлтэй боловч ажлын чадвар хязгаарлагдаагүй, хөдөлмөрийн чадвартай хүмүүс орно.

3.6.3. **Эрүүл мэндийн 3-р бүлэг:** Ээнэгшил бүхий архаг өвчтэй хүн - Энэ бүлэгт лаборатори болон багажийн шинжилгээгээр онош нь батлагдсан, архаг өвчин нь сэдрэлгүй, өвчин нь төгс эмчлэгдэх бүрэн боломжтой, ажлын чадвар нь хязгаарлагдаагүй, хөдөлмөрийн чадвартай хүмүүс орно. *(Ээнэгшил гэдэг нь жилд 2-оос доошгүй өвчний дахилт илрээгүй тохиолдлыг хэлнэ.)*

3.6.4. **Эрүүл мэндийн 4-р бүлэг:** Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй хүмүүс- Энэ бүлэгт лаборатори болон багажийн шинжилгээгээр онош нь батлагдсан, архаг өвчин нь үе үе сэдрэлтэй, бусад өвчнүүдтэй хавсарсан, өвчний хүндрэл өгөх магадлал өндөртэй, ажлын чадвар хязгаарлагдаагүй боловч хөдөлмөрийн чадвараа тодорхой хэмжээгээр алдсан хүмүүс орно. *(Хагас ээнэгшил гэдэг нь жил бүр өвчний дахилт явагдаж хөдөлмөрийн чадвараа 1 сараас илүүгүй хугацаагаар алдсаныг хэлнэ.)*

3.6.5. **Эрүүл мэндийн 5-р бүлэг:** Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй хүмүүс хамрагдана. Энэ бүлэгт лаборатори болон багажийн шинжилгээгээр онош нь батлагдсан, архаг өвчин нь байнгын сэдрэлтэй, бусад өвчнүүдтэй хавсарсан, өвчний хүндрэлийн зэрэг нь 2-3, хөдөлмөрийн чадвараа алдсан, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан хүмүүс орно. *(Ээнэгшлээ алдсан гэдэг нь өвчний дахилт олширсон, 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдахыг хэлнэ.)*

3.7. Эрүүл мэндийн байдлаар нь айл, өрхийг ангилах:

3.7.1. **Эрүүл өрх:** Эрүүл мэндийн III-V бүлэгт хамаарагдах архаг өвчтэй хүн байхгүй бөгөөд жилд өрхийн аль нэг гишүүн нь өвчилж үзүүлсэн тоо нэгээс илүүгүй байна.

3.7.2. **Эрүүл мэндийн бага өртөмтгий өрх:** Гэр бүлийн дотор архаг өвчтэй хүн нэгээс илүүгүй бөгөөд жилд өрхийн нэг гишүүн хурц халдварт өвчнөөр 3-аас илүүгүй удаа өвчилж үзүүлсэн байна.

3.7.3. **Эрүүл мэндийн өртөмтгий өрх:** Гэр бүлийн дотор архаг өвчтөн 2 ба түүнээс олон, жилд өрхийн нэг гишүүн хурц халдварт өвчнөөр

өвчилсөн тоо 3-аас олон байна. (Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ганц бие өндөр настан, бүтэн өнчин, хагас өнчин хүүхэдтэй, хорт хавдар, сүрьеэ, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүнтэй өрхийг энд хамааруулна.)

3.8. Төв нь хүн амын эрүүл мэндтэй холбоотой анхдагч өгөгдлийн мэдээллийн санг ашиглах, шинэчлэх, түүний хадгалалт, хамгаалалт, ашиглалтын зохих нөхцөлийг бүрдүүлэн холбогдох дүрэм журмын хүрээнд ажиллана.

3.9. Эмчийн үзлэг болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдлыг холбогдох журам, маягтын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэт, давхардалгүйгээр цахим эсхүл цаасан хэлбэрээр бүртгэнэ.

3.10. Жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилгоор төвүүд зарим тусламж үйлчилгээг хамтран гэрээлэн гүйцэтгэж болно.

3.11. Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг биелүүлэх зорилгоор зарим үйлчилгээг тухайн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно.

3.12. Харьяаллын болон бүртгэлтэй хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн үйл ажиллагаанд жил бүр дүн шинжилгээ хийж, тулгамдаж байгаа асуудал, тухайн тусламж үйлчилгээнээс орхигдож байгаа хүн амын бүлгийг тодорхойлон хүн амд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах үр дүнг тодорхойлон хэрэгжүүлж ажиллана.

3.13. Төв нь харьяаллын болон бүртгэлтэй хүн амын амын эрүүл, сайн сайхан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг хангах үүднээс засаг захиргааны холбогдох бусад нэгжүүдтэй хамтран ажиллаж, үр дүнг тооцож ажиллана.

3.14. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч ажиллана.

3.15. Төв нь байгууллагын соёл, ажлын байрны эмх цэгц, орчны ээлтэй, тав тухтай байдлыг хангаж, ёс зүй, харилцааны соёлыг нэвтрүүлж, угтах үйлчилгээтэй ажиллана.

3.16. Төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх журмыг баримтлан, цаг товлох, эргэн дуудах тогтолцоог нэвтрүүлэн, хэрэгжүүлнэ.

3.17. Эмнэлгийн анхан шатны болон яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлж, шаардлагатай бол дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

3.18. Лавлагаа шатлалын эмнэлгийн зөвлөмжийн дагуу үйлчлүүлэгчийн эмчилгээг үргэлжлүүлэн, хяналт тавьж ажиллана.

3.19. Шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн яаралтай тусламжийн багийг дуудаж, газар дээр нь тусламж, үйлчилгээг

үзүүлэх нөхцөлийг хангаж, хамтран ажиллана.

3.20. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг сар, улирал бүр дүгнэлт хийж ажиллана.

3.21. Эмзүйн тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан заавар, журмын дагуу гүйцэтгэнэ.

3.22. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан зайлшгүй шаардлагатай ба яаралтай тусламжийн жагсаалтад заасан эмээр хангагдсан байна.

3.23. Улсын бүртгэлд бүртгэгдсэн чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх, эмийн тун, үл нийцэл, гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг хангаж ажиллана.

3.24. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, нөөц, чанар, эмийн зохистой хэрэглээ, захиалга, зарцуулалтад төвийн дарга хяналт тавина.

3.25. Халдваргүйтгэл, ариутгал, хог хаягдлын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан тушаал, зааврыг мөрдөж ажиллана.

ДӨРӨВ. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

4.1. Төв нь тусламж үйлчилгээндээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт технологи болон дүрэм, журам, зааврыг мөрдөж, энэхүү журмын хавсралтад заасан тусламж, үйлчилгээг дараах хүрээ, хэлбэрийн дагуу үзүүлнэ. Тусламж, үйлчилгээний хүрээ:

- 4.1.1. Эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх
- 4.1.2. Оношлох
- 4.1.3. Эмчлэх
- 4.1.4. Сувилах
- 4.1.5. Өвчнөөс урьдчилан сэргийлэх
- 4.1.6. Эрүүл мэндийн байдлыг хянах
- 4.1.7. Эрүүл мэндийг дэмжих
- 4.1.8. Сэргээн засах тусламж, үйлчилгээ
- 4.1.9. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ
- 4.1.10. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

4.2. Тусламж, үйлчилгээ үзүүлэх хэлбэр:

- 4.2.1. Гэрээр
- 4.2.2. Амбулаториор
- 4.2.3. Өдрийн эмчилгээ
- 4.2.4. Хэвтүүлэн эмчлэх

4.1.1. Эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх:

- 4.1.1.1. Хүүхэд/өсвөр үеийнхний хүүхдүүдийн эрүүл мэндийн үнэлгээ;
- 4.1.1.2. Насанд хүрэгчдийн эрүүл мэндийн үнэлгээ;
- 4.1.1.3. Ахмад настны эрүүл мэндийн цогц үнэлгээ (ICOPE);

4.1.2. Оношлох:

- 4.1.2.1. Лабораторийн шинжилгээ;
- 4.1.2.2. Багажийн оношилгоо;
- 4.1.2.3. Сорьц цуглуулах, тээвэрлэх;

4.1.3. Эмчлэх:

- 4.1.3.1. Өвчний учир үзлэг (ОУӨА-10);
- 4.1.3.2. Яаралтай тусламж, үйлчилгээ;

4.1.4. Сувилах:

- 4.1.4.1. Архаг явцтай, хүнд өвчтэй хүнийг урт хугацаанд сувилах тусламж, үйлчилгээ
- 4.1.4.2. Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ,
- 4.1.4.3. Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ

4.1.5. Өвчнөөс урьдчилан сэргийлэх:

- 4.1.5.1. Дархлаажуулалтад хамруулах;
 - 4.1.5.1.1. Товлолт дархлаажуулалт
 - 4.1.5.1.2. Нөхөн дархлаажуулалт
 - 4.1.5.1.3. Нэмэлт дархлаажуулалт
 - 4.1.5.1.4. Тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт

4.1.5.2. Эрт илрүүлэг;

4.1.5.2.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг

- 4.1.5.2.1.1. Амны хөндийн эмгэг
- 4.1.5.2.1.2. Сэтгэц зан төрхийн эмгэг
- 4.1.5.2.1.3. Чихрийн шижин хэв шинж-II
- 4.1.5.2.1.4. Цусны даралт ихсэх өвчин
- 4.1.5.2.1.5. Дислипидеми өвчин
- 4.1.5.2.1.6. Уушгины архаг бөглөрөлт өвчин
- 4.1.5.2.1.7. Бөөр шээс дамжуулах замын өвчин
- 4.1.5.2.1.8. Хоол боловсруулах замын өвчин
- 4.1.5.2.1.9. Хавдар
 - 4.1.5.2.1.9.1. Умайн хүзүүний хавдар
 - 4.1.5.2.1.9.2. Элэгний хорт хавдар
 - 4.1.5.2.1.9.3. Улаан хоолойн хорт хавдар
 - 4.1.5.2.1.9.4. Ходоодны хорт хавдар
 - 4.1.5.2.1.9.5. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар
 - 4.1.5.2.1.9.6. Хөхний хорт хавдар
- 4.1.5.2.1.10. Сургуульд суурилсан хүүхдийн эрт илрүүлэг

4.1.5.2.2. Халдварт өвчний эрт илрүүлэг;

- 4.1.5.2.2.1. Сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ
- 4.1.5.2.2.2. Сүрьеэ өвчнөөр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гаргах, тогтмол шинэчлэх
- 4.1.5.2.2.3. Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт
- 4.1.5.2.2.4. БЗДХ/ ХДХВ/ ДОХ
- 4.1.5.2.2.5. Гепатит В
- 4.1.5.2.2.6. Гепатит С

4.1.5.2.2.7. Сорьц цуглуулах, тээвэрлэх

4.1.5.3. Халдварт өвчний тандалт;

- 4.1.5.3.1. Цочмог халдварт өвчний тархвар зүйн үнэлгээ, дүгнэлт хийхэд дэмжлэг үзүүлэх
- 4.1.5.3.2. Сүрьеэгийн шинэ тохиолдлын гэр бүл болон ойрын хавьтлын үзлэг, хяналт
- 4.1.5.3.3. Тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, баталгаажуулах, илгээх, мэдээлэх

4.1.6. Эрүүл мэндийн байдлыг хянах:

- 4.1.6.1. Зүрхний архаг эмгэгүүд;
- 4.1.6.2. Чихрийн шижин хэв шинж-II;
- 4.1.6.3. Цусны даралт ихсэх өвчин;
- 4.1.6.4. Дислипидеми өвчин;
- 4.1.6.5. Шууд хяналттай сүрьеэгийн өдрийн эмчилгээ, хяналт;
- 4.1.6.6. Гепатит В, С;
- 4.1.6.7. Хавдар;
- 4.1.6.8. Жирэмсний хяналт;
- 4.1.6.9. Төрсний дараах эхийн хяналт;
- 4.1.6.10. Ахмад настны хяналт;
- 4.1.6.11. Нярайн хяналт;
- 4.1.6.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хяналт;
- 4.1.6.13. Лавлагаа шатлалын эмнэлгээс илгээсэн архаг өвчтөний хяналт;
- 4.1.6.14. Уушгины архаг бөглөрөлт өвчин;
- 4.1.6.15. Бөөр шээс дамжуулах замын өвчин;
- 4.1.6.16. Хоол боловсруулах замын өвчин
- 4.1.6.17. Бусад;

4.1.7. Эрүүл мэндийг дэмжих:

- 4.1.7.1. Хувь хүнд чиглэсэн зөвлөмж;
 - 4.1.7.1.1. Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үе
 - 4.1.7.1.2. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга
 - 4.1.7.1.3. Хүүхэд, нярайн асаргаа
 - 4.1.7.1.4. Эрүүл хооллолт
 - 4.1.7.1.5. Дасгал хөдөлгөөн хийх
 - 4.1.7.1.6. Тамхины хэрэглээг бууруулах
 - 4.1.7.1.7. Архи, донтолтоос сэргийлэх
 - 4.1.7.1.8. Сэтгэцийн эрүүл мэнд
 - 4.1.7.1.9. Эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих
 - 4.1.7.1.10. Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих
 - 4.1.7.1.11. Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих
 - 4.1.7.1.12. Чих, сонсгол хамгаалах
 - 4.1.7.1.13. Нүд хамгаалах
 - 4.1.7.1.14. Амны хөндийн эрүүл мэнд
 - 4.1.7.1.15. Осол, гэмтлээс сэргийлэх

4.1.7.1.16. Халдварт өвчний эрсдэлт зан үйлийг бууруулах /гар угаах, амны хаалт хэрэглэх, зөв ханиаж найтаах болон бусад эрүүл ахуйн зөвлөмж/

4.1.8. Сэргээн засах:

- 4.1.8.1. Үйл ажиллагааны чадварын үнэлгээ, төлөвлөгөө гаргах
- 4.1.8.2. Хөдөлгөөн засал,
- 4.1.8.3. Хөдөлмөр засал;
- 4.1.8.4. Физик эмчилгээ;
- 4.1.8.5. Эрүүл мэндийн боловсрол;
- 4.1.8.6. Туслах хэрэгсэл, төхөөрөмжийн тохируулга.

4.1.9. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ:

- 4.1.9.1. Өдрийн эмчилгээ;
- 4.1.9.2. Амбулатори;
- 4.1.9.3. Хэвтэн эмчилгээ;

4.1.10. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ:

4.1.10.1. Хөнгөвчлөх эмчилгээ

- 4.1.10.1.1.1. Өвдөлтийн үнэлгээ
- 4.1.10.1.1.2. Тавилан тогтоох Карновскийн үнэлгээ
- 4.1.10.1.1.3. Хяналтын эмчийн зөвлөсөн эмчилгээг хийх;
- 4.1.10.1.1.4. Шаналтгаат шинжийн менежмент
- 4.1.10.1.1.5. Өвчтөн гэртээ нас барсан тохиолдолд цогцос цэгцлэх, ар гэрт зөвлөгөө өгөх

4.1.10.2. Хөнгөвчлөх сувилахуй

- 4.1.10.2.1.1. Хэвтрийн холголт цооролт,
- 4.1.10.2.1.2. Эдгэрэх ба үл эдгэрэх шархны менежмент;
- 4.1.10.2.1.3. Өтгөн хаталттай буюу шингэн алдах үед;
- 4.1.10.2.1.4. Шээс хаагдсан эсвэл задгайрсан үед,
- 4.1.10.2.1.5. Стомын арчилгаа;

5. ТАВ. СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь яаралтай тусламжийн нэгж, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулна.

5.2. Түргэн тусламжийн үйлчилгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, зааврын дагуу үзүүлнэ.

5.3. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, зааврын дагуу үзүүлнэ.

5.4. Тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн, тоног төхөөрөмжөөр

хангагдсан, мэргэшсэн эмчтэй сумын эрүүл мэндийн төвд мэс засал, шүдний тусламжийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, зааврын дагуу үзүүлнэ.

5.5. Цус, цусан бүтээгдэхүүний үйлчилгээ

5.5.1. Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, цус сэлбэх шаардлага гарсан үед бэлэн байдлыг хангах үүрэг, хариуцлагыг сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга хүлээнэ.

5.5.2. Төв нь нийт хүн амынхаа нэг хүртэлх хувьтай тэнцэх цусны донорыг элсүүлэн бэлтгэж, тогтмол шинжилгээнд хамруулж. эрүүл, аюулгүй цусны бэлэн байдлыг хангана.

5.5.3. Яаралтай цус сэлбэх (төрөх, осол гэмтэл, мэс засал) тохиолдолд бүхэл цус цуглуулж, батлагдсан стандарт, дүрэм, журам, зааврыг мөрдөж, эмчилгээнд хэрэглэнэ.

5.5.4. Цус цуглуулж эмчилгээнд хэрэглэсэн тохиолдол бүрд донороос шинжилгээний сорьцыг авч, аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторид илгээн халдвар илрүүлэх нэмэлт шинжилгээг энзим иммун болон химолюминесценцийн аргаар хийлгүүлэн хариуг авч донорын картад хавсаргана.

5.5.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь цусны донор сонгох, эрүүл мэндийн үзлэг хийх, цус цуглуулах, цусны бүлгүүд тодорхойлох, цус сэлбэлтээр дамждаг халдвар илрүүлэх шинжилгээ хийх, цус сэлбэх аюулгүй ажиллагааг хангах аргачлалд сургагдсан, ур чадвар эзэмшсэн байна.

ЗУРГАА. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

6.1. Анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг баримтлах бөгөөд үнэлгээнд дараах үзүүлэлт, мэдээлэл, үнэлгээний дүнг тусгана. Үүнд:

6.1.1. Энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан анхан шатлалын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт;

6.1.2. Мэдээллийн ил тод байдал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн opendata.1313.mn цахим хуудсанд байршуулсан мэдээлэл;

6.1.3. Дэмжлэгт хяналт, үнэлгээ, шийдвэрийн хэрэгжилтийг үнэлгээний дүн.

6.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар үнэлж дүгнэлтийг жил бүрийн 6 дугаар сарын 5, 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2026 оны
 сарын өдрийн дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

НЭГ. ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Тусламж, үйлчилгээ хүрээ	Тусламж, үйлчилгээний жагсаалт	ICD10-1	Хийгдэх үйлдлийн жагсаалт	Насны болон хамаарах хүн амын бүлэг	Давтамж	ӨЭМТ	СТЭМТ	Тусламж, үйлчилгээ үзүүлэх хэлбэр				Суурь тусламж, үйлчилгээ
								Амбулаториор	Гэрээр	Хэвтэн	Өдрийн эмчилгээ	
Эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх	Биеийн ерөнхий үнэлгээ	Z00.0, Z00.1, Z00.2, Z00.3	Асуумж авах, жин, өндөр, толгой, бүсэлхийн тойрог хэмжих, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	Бүх нас	Жилд 1 удаа	√	√	√				√
	Хүүхдийн хөгжлийн үнэлгээ	Z00.1, Z00.2	Хүүхдийн хөгжлийн асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, Морбас үнэлгээ хийх	9 сар, 18 сар, 36 сар, 48 сар, 60 сар	Товлосон хугацаанд 1 удаа	√	√	√	√			√
	Өсвөр үеийнхний өсөлт хөгжлийн үнэлгээ	Z00.3	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	10 - 19 нас	Жилд 1 удаа	√	√	√				√
	Ахмад настны эрүүл мэндийн үнэлгээ (ICOPe)	Z00.0	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, I II III түвшинд хуваан эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих төвүүдэд холбох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, урт хугацааны асаргаанд хамруулах	60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	Жилд 1 удаа	√	√	√	√			√

	Хувь хүний эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ	Z00.0	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	18+ нас	Жилд 1 удаа	√	√	√				√
Халдварт бус өвчний эрт илрүүлэг	Амны хөндийн эмгэгийн илрүүлэг	Z13.8	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	18 сар – 6 нас, 11-15 нас	Тухайн насанд 1 удаа	√	√	√				√
	Сэтгэц, зан төрхийн эмгэгийн илрүүлэг	Z13.3	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	6 нас, 14 нас, 21 нас, 45 нас, 60 нас	Тухайн насанд 1 удаа	√	√	√				√
	Хоёрдугаар хэлбэрийн чихрийн шижин өвчний илрүүлэг	Z13.1	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хяналтад бүртгэх	35+ нас	жилд 1 удаа	√	√	√				√
	Цусны даралт ихсэх өвчний илрүүлэг	Z13.6	Асуумж авах, даралт хэмжих, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хяналтанд бүртгэх	18+ нас	жилд 1 удаа	√	√	√				√
	Дислипидеми өвчний илрүүлэг	Z13.8	Асуумж авах, оношилгоо, шинжилгээ хийх эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хяналтад бүртгэх	40+ нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
	Зүрх судасны өвчний эрсдэлийн үнэлгээ	Z13.6	Асуумж авах, даралт хэмжих, оношилгоо, шинжилгээ хийх эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хяналтад бүртгэх	40+ нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
	Сургуульд суурилсан хүүхдийн эрт илрүүлэг	Z02.0, Z10.8	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, боловсролын байгууллагатай хамтран хараа шалгах, сонсгол үнэлэх, зүрхний цахилгаан бичлэг хийх	6, 11, 15 нас	Тухайн насны хүүхдэд 1 удаа	√	√	√	√			
Халдварт өвчний эрт илрүүлэг	Сүрьеэ өвчний илрүүлэг	Z11.1	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, хяналтанд бүртгэх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлэх	6+ нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
	БЗХӨ-ний илрүүлэг	Z11.3	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлэх	18 - 45 нас	3 жилд 1 удаа	√	√	√				√

	ДОХ-ын илрүүлэг	Z11.4	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлэх	18 - 45 нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
	В гепатитын илрүүлэг	Z11.5	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлэх	18 + нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
	С гепатитын илрүүлэг	Z11.5	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлэх	18 + нас	3 жилд 1 удаа	√	√	√				√
Хорт хавдрын эрт илрүүлэг	Умайн хүзүүний хавдрын илрүүлэг	Z12.4	Дуудах, урилга хүргүүлэх, умайн хүзүүний эсийн шинжилгээний наац авах ба ХПВ шинжилгээний сорьц авах, лавлагаа шатлалд илгээх, эргэж бүртгэх	УХХХ-ийн эсийн шинжилгээн ий наац 27 ба 45-аас 63 хүртэлх насны эмэгтэйд, ХПВ шинжилгээн ий сорьц 30, 40 насны эмэгтэйд	Тухайн насанд болон 3 жилд 1	√	√	√				√
	Хөхний хавдрын илрүүлэг	Z12.3	Асуумж авах, эмчийн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	40-70 насны эмэгтэйчүүд	Тухайн насны эмэгтэйчүүдэд 2 жилд 1 удаа	√	√	√				√
	Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг	Z12.9	Дуудах, урилга хүргүүлэх , В, С вирусийн түргэвчилсэн сорил хийх, лавлагаа шатлалд илгээх, эргэж бүртгэх, хянах	18+ нас	жилд 1 удаа	√	√	√				√

	Улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэг	Z12.9	Дуудах, урилга хүргүүлэх , лавлагаа шатлалд дуран оношилгоонд илгээх, эргэж бүртгэх	40<	2 жилд 1	√	√	√				√
	Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг	Z12.0	Дуудах, урилга хүргүүлэх , лавлагаа шатлалд дуран оношилгоонд илгээх, эргэж бүртгэх	40<	2 жилд 1	√	√	√				√
	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг	Z12.1	Дуудах, урилга хүргүүлэх, өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээнд хамруулах , лавлагаа шатлалд дуран оношилгоонд илгээх, эргэж бүртгэх	45 <	2 жилд 1	√	√	√				√
Халдварт өвчний тандалт	Цочмог халдварт өвчний тархвар зүйн үнэлгээ, дүгнэлт хийхэд дэмжлэг үзүүлэх	Z29.0, Z29.8, Z29.9	Цочмог халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, асуумж авах, сорьц авах, лавлагаа шатлалд илгээх, эргэж бүртгэх	Бүх нас	Тохиолдол бүрт	√	√					√
	Гэр бүлийн болон ойрын хавьтлын тандалт	Z20	Сүрьеэ болон цочмог халдварт өвчний тандалтын асуумж авах, сорьц авах, лавлагаа шатлалд илгээх, эргэж бүртгэх	Эерэг тохиолдол	Тохиолдол бүрт							√
	Сүрьеэ өвчнөөр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гаргах, тогтмол шинэчлэх	-	Сүрьеэ өвчнөөр өвдөх эрсдэлт бүхий хүн амын жагсаалт									√
	Сүрьеэгийн эмийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх											√
Эрүүл мэндийг хянах	Хоёрдугаар хэлбэрийн чихрийн шижин өвчний хяналт	Z09.8 давхар кодлол E11	Өвчтөнийг дуудах, оношилгоо шинжилгээ хийх, БЖИ үзэх, эмчийн үзлэг хийх, амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд илгээх,	Онош батлагдсан бүх хүн	Жилд 4<	√	√	√				√

			лавлагаа шатлалаас хяналтанд авах									
Дислипидеми өвчний хяналт	Z09.8 давхар кодлол E78	Өвчтөнийг дуудах, цусны даралт хянах, үзлэг, оношилгоо хийх, амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Онош батлагдсан бүх хүн	Жилд 4<	√	√	√					√
Зүрх судасны эмгэгийн хяналт	Z09.8 давхар кодлол I10, I11, I12	Өвчтөнийг дуудах, цусны даралт хянах, үзлэг, оношилгоо хийх, амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Онош батлагдсан бүх хүн	Жилд 4<	√	√	√					√
Сүрьеэ өвчний хяналт	Z09.8 давхар кодлол A15, A16, A17, A18, A19	Өвчтөнийг дуудах, үзлэг, оношилгоо хийх, сүрьеэгийн диспансертай хамтран эмийн эмчилгээг хийх , амьдралын хэв маягийг өөрчлөх зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Онош батлагдсан бүх хүн	Жилд 4<	√	√	√	√				√

Жирэмсний хяналт	Z34, Z35	Эхийг дуудах, үзлэг, оношилгоо хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Жирэмсэн эмэгтэй	Товлолын дагуу нийт 8 удаа	√	√	√	√			√
Төрсний дараах эхийн хяналт	Z39.2	Эхийг дуудах/гэрт очих, үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Төрснөөс хойш 2 сарын дотор	Товлолын дагуу 3 удаа , шаардлагатай тохиолдолд нэмэлтээр	√	√	√	√			√
Нярайн хяналт	Z00.1	Нярайг дуудах/гэрт очих, үзлэг хийх, эхэд зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Төрснөөс хойш 2 сарын дотор	Товлолын дагуу 4 удаа, шаардлагатай тохиолдолд нэмэлтээр	√	√	√	√			√
Ахмад настны хяналт	Z10.1	Үе мөчний үзлэг, хараа шалгах, сонсгол шалгах, зөвлөгөө өгөх	55/60 <	2 жилд 1 удаа	√	√	√	√			√
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт	Z73.6	Үзлэг хийх, зөвлөгөө өгөх, нийгмийн халамжид хамруулах	бүх нас	Жилд 1 удаа	√	√	√	√			√
ICF үйл ажиллагаа , хөгжлийн бэрхшээл үйлдлийн чадамж	Z73.6	Биеийн бүтэц, үйл ажиллагаа, үйлдэл гүйцэтгэх чадвар, нийгмийн оролцоог үнэлэх	Бүх насны хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Жилд 1 удаа	√	√	√	√			√

	Бусад хяналт /13Б/	Z09.8 давхар кодлол А00-У98	Өвчтөнийг дуудах, үзлэг хийх, зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмийн жор бичих, дараагийн үзлэгийн тов тогтоох, лавлагаа шатлал руу илгээх, лавлагаа шатлалаас хяналтандаа авах	Лавлагаа шатны ЭМБ-аас анхан шатны ЭМБ-ын хяналтанд илгээсэн хүн	Эмчилгээн ий горимын дагуу	√	√	√				√
Эрүүл мэндийг дэмжих	Нярай хүүхдийн асаргааны зөвлөмж	Z71.9	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	2 сар хүртэл	Товлолын дагуу 4 удаа, шаардлага тай тохиолдолд нэмэлтээр	√	√	√				√
	Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн зөвлөмж	Z71.9	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Төрөх насны эмэгтэйчүүд	Тухай бүр	√	√	√				√
	Гэр бүл төлөвлөлт/жирэмслэлтэ эс сэргийлэх зөвлөмж	Z30.0	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Төрөх насны эмэгтэйчүүд	Тухай бүр	√	√	√				√
	Эрүүл хооллолтын зөвлөмж	Z72.4	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Дасгал хөдөлгөөн хийх зөвлөмж	Z72.3	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Тамхинаас гарах зөвлөмж	Z72.0	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Архины хэрэглээг бууруулах зөвлөмж	Z72.1	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Донтолтоос сэргийлэх зөвлөмж	Z72.2	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Сэтгэцийн эрүүл мэндийн ерөнхий зөвлөмж	Z73	Эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө өгөх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√

Өвчнөөс урьдчилан сэргийлэх	Товлолт дархлаажуулалт	Z23.2, Z24.6, Z24.0, Z27.8, Z27.4, Z27.8, Z24.6	Сүрьеэ, В гепатит, Халдварт саа, Сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюс инфлюэнза /тавт вакцин/, Улаан бурхан, гахайн хавдар, улаанууд, Сахуу, татран /хоёрт вакцин/, А гепатит, Пневмококк, Хүний папилома вирус	Төрснөөс хойш 24 цагийн дотор, 2 сар, 3 сар, 4 сар, 9 сар, 1 нас 2 сар, 2 нас, 7 нас, 11 нас, 15 нас	Товлолын дагуу тухайн насанд	√	√	√				√
	Нөхөн дархлаажуулалтын нэр	Z26.8	Дуудах, үзлэг хийх, дархлаажуулалт хийх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Нэмэлт дархлаажуулалтын нэр	Z26.8	Дуудах, үзлэг хийх, дархлаажуулалт хийх	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
	Тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтын нэр	Z26.8	Халдварт саа, улаанбурхан, сахуу, хөхүүл ханиад, улаанбурхан, гэдэсний балнад, боом	Бүх нас	Тухай бүр	√	√	√				√
Сэргээн засах	Үйл ажиллагааны чадварын үнэлгээ, төлөвлөгөө гаргах	Z51.8	<p>Үнэлгээг оношийн бүлгээс хамаарч сонголтоор хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Өвдөлт - VAS • Үений далайц -ROM • Булчингийн хүч- MMT • Булчингийн тэсвэр • Өвөрмөц сорил • Алхаа /Timed up and go test/ • Тэнцвэр /Berg Balance test/ • 6 минутын сорил • SIAS үнэлгээ • Brunnstrom <p>Чадвар алдалтын үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> • Роналд Моррис, WOMAC, Neck Disability index • Barthel index <p>Өдөр тутмын үйл ажиллагаа болон хөдөлгөөний чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Functional Independence Measure- FIM • Үйлдлийн задлан шинжилгээ • Хөдөлмөрийн дүн шинжилгээ 	Урт ба богино хугацааны чадвар алдагдалтай бүх насныхан	Тухай бүр / сар бүр / улиралд	√	√	√	√	√	√	

		<p>Гүйцэтгэлт үйл ажиллагаа, анхаарал, ой санамж, танин мэдэхүй</p> <ul style="list-style-type: none"> • Montreal Cognitive Assessment (MoCA) • The Model of Human Occupation Screening Tool (MOHOST) • Pediatric Evaluation of Disability Inventory (PEDI) <p>Орчин талаас</p> <ul style="list-style-type: none"> • Home Falls and Accidents Screening Tool (Home FAST) <p>Гэрийн үнэлгээ</p>										
Хөдөлгөөн засал	Z51.8	<ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөн заслын үнэлгээ • Хөдөлгөөн заслын тусламж, үйлчилгээ /оношийн бүлгээс хамаарч сонгоно/: <ul style="list-style-type: none"> - Үений мобилизаци, далайц, хүч, тэнцвэр, сунгалт, тэсвэр, үений тогтвортой байдлыг сайжруулах, алхаа - Мэдрэхүй-хөдөлгөөний дахин сургах - Амьсгалын дасгалууд, байрлал эмчилгээ • Гэрийн үйлчилгээний хөтөлбөр гаргах <p>Үр дүн үнэлэх /давтан/</p>	Бүх нас	Тухай бүр / сар бүр / улиралд	√	√	√	√	√	√		
Хөдөлмөр засал	Z51.8	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр заслын үнэлгээ • Хөдөлмөр заслын тусламж үйлчилгээ /оношийн бүлгээс хамаарч сонгоно/: <ul style="list-style-type: none"> - Мэдрэхүй-хөдөлгөөний үйл ажиллагаа - Өдөр тутмын үйл ажиллагаа - Танин мэдэхүй - Нийгмийн оролцоо - Орчны тохируулга - Туслах хэрэгсэл ашиглаж сургах 	Бүх нас	Тухай бүр / сар бүр / улиралд	√	√	√	√	√	√		

			<ul style="list-style-type: none"> - Дарагдлын шарх үүсэхээс сэргийлж байрлал солих аргачлалд сургах - Үе хамгаалах техник - Энерги нөөх арга - Хавангийн менежмент - Өвдөлтийн менежмент - Өдөр тутмын үйл ажиллагааны хэв маягийг тогтворжуулах - Амьдралын хэв маягийн менежмент хийх - Сэтгэл хөдлөлийн зохицуулалт - гүйцэтгэлт үйл ажиллагааны чадвар - бүлгийн үйл ажиллагааны нийгмийн харилцааны чадвар сайжруулах - Ур чадварт сургаж ажил эрхлэлтэд бэлтгэх • Гэрийн үйлчилгээний хөтөлбөр гаргах • Үр дүн үнэлэх /давтан/ 										
Физик эмчилгээ	Z51.8	Зайлшгүй: <ul style="list-style-type: none"> • Халуун жин /Hot pack/ • Хүйтэн жин /Cold pack/ • TENS / ICT • Ultrasound • FES Нэмэлт /сонголтоор/: <ul style="list-style-type: none"> • Laser • Парафин • Инфра улаан /Infrared/ • NMES Бусад	Бүх нас	Тухай бүр /сар бүр/ улиралд	√	√	√	√	√	√			
Эрүүл мэндийн боловсрол	Z51.8	Оношийн бүлгээс хамаарч сонгоно: <ul style="list-style-type: none"> • Үл ашиглах хам шинжээс урьдчилан сэргийлэх 	Бүх нас	Тухай бүр 5 удаа	√	√	√	√	√	√	√	√	

			<ul style="list-style-type: none"> • Үе хамгаалах техник • Хөдөлгөөний идэвх, түүний ач холбогдол • Ачаалалаа тохируулах, өөрийгөө хянах • Унах эрсдэлээс сэргийлэх арга • Эцэг эхчүүдэд мэдрэхүйн ялгаатай байдлыг ойлгуулах зөвлөгөө • Зөв амьдралын хэв маягийг зөвлөх • Гэрийн орчны тохируулгын талаарх зөвлөгөө • Зөв байрлалын ач холбогдол (холголт цооролт) • Зөв төрх байдал (posture)-ын ач холбогдол • Асран хамгаалагчдад зориулсан халшрах хам шинжийн зөвлөгөө • Гэрээр хийх дасгалын хөтөлбөр заах 										
	Туслах хэрэгсэл, төхөөрөмжийн тохируулга, зөвлөгөө	Z51.8	<ul style="list-style-type: none"> • Таяг тохируулах, ашиглах • Тэргэнцэр тохируулах, ашиглах • Алхуулагч /walker/ • Чиг /splint, brace, AFO/ • Нэмэлт зөөлөвч, ивээс • Урт гар • Оймс өмсөгч • Гутал өмсөгч • Хүзүүний бэхэлгээ • Нурууны бүс • Бариул зузаан болгогч • Био суултуур • Халтирахаас хамгаалах дэвсгэр 	Бүх нас	Тухай бүр	√	√	√	√	√	√		√
	Үйл ажиллагааны чадварыг үнэлэх, төлөвлөгөө гаргах:												
Сэргээн засах	Алхааны сорил (timed up and go test)	Z51.8	Алхах чадвар, тэнцвэр, булчингийн хүч, зүрх уушгины тэсвэрийг үнэлэх	Бүх нас		√	√	√	√	√	√		

Тэнцвэрийн сорил (Berg Balance test)	Z51.8	Биетийн байрлалын хяналт, мэдрэхүйн зохицуулалт, булчингийн хариу үйлдэлийг үнэлэх	Бүх нас		√	√	√	√	√	√	
6 болон 2 минутын алхааны сорил	Z51.8	Зүрх уушгины тэсвэр, үйл ажиллагааны чадвар, алхалтын гүйцэтгэл үнэлэх	Бүх нас		√	√	√	√	√	√	
